

- Усны тэмдэг
- Шилжилтийн тэмдэг
- Завсрын тэмдэг

Монгол-Хятадын хилд:

- Төрийн сүлдтэй хилийн цементэн багана
- Хилийн дангаар босгосон чулуун овоо тэмдэг
- Хилийн дангаар босгосон цементэн багана
- Хилийн дангаар босгосон цементэн суурьтай цементэн

багана

Б. Хилийн овоо

- Дундын овоо
- Дангаар босгосон овоо
- Хосоор босгосон овоо

В. Хөвөгч тэмдэг

Г. Гурван улсын хилийн уулзвар дээр гурван хөлтэй суурин дээр босгосон пирамид эдгээр болно.

Ахлах багш, дэд хурандаа Д.Шаравшагдар

Л.В. Потапов (Буриадын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Засгийн Газрын тэргүүн)

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТ-НИЙТ АРД ТҮМНИЙ ҮЙЛ ХЭРЭГ МӨН

Оросын Холбооны Улсын Монголтой хиллэдэг Буриадын хилийн хэсгийн өнөөгийн нөхцөл байдал нь Буриад улсын удирдлагын сэтгэлийг нэлээд түгшээж байдаг юм. Юу гэвэл Буриадын нутаг дэвсгэрээр дайран гарч буй Монголтой хиллэдэг 1275 км хилийн хэсгийн 680 км нь цэргийн хүч хэрэгслээр халхлагдаж хамгаалагдаагүй учраас жилд үйлдэгдэж буй улсын хил түүний дэглэмийн зөрчлийн 70 илүү хувь нь энэ хэсгээр гарч тэдгээрийн дийлэнхи хувийг малын хулгай, контрбанд зэрэг хууль бус үйлдлүүд эзэлж байна.

Контрбандын үйл ажиллагаа хууль бусаар хил дамнуулан гуравдагч оронд гаргах оросын бараа түүхий эдийн хэмжээ нэмэгдсээр байна.

Бидний авсан мэдээгээр Монголын гэмт хэргийн бүлэглэлийнхэн ОХУ-д ихээхэн хэмжээний галт хэрэгсэл оруулж наймаалах боломжийг судалж байгаа бололтой.

Оросын гэмт хэргийн бүлэглэлүүдийн анхаарлыг ихээхэн татаж байгаа зүйл бол монголын хил орчимд ургадаг зэрлэг ороонго өвс (кнопля) ургадаг нутгууд болж байна.

1995 онд тус цэргийн тойргийн хариуцсан хэсгээр контрбандын 15 гаруй суваг илрүүлж, 4.5 тэрбум рублийн контрбандын эд зүйлс хураан авлаа.

Гэхдээ контрбандын үйл ажиллагаа бодит хэмнэл нь ялангуяа хил нэвтрэх пунктын гадуур үүнээс ч илүү байгаа гэдгийг үгүйсгэхгүй.

Тодорхой арга хэмжээ авч байгаа боловч улсын хил, түүний дэглэмийн зөрчил болон бусад хууль бус үйлдлүүд таслан зогсоогдохгүй байна. Улсын хилийг бэхжүүлэх хэрэгтэй. Өнгөрсөн жил Байгалын чанд дахь хилийн тойргийн санхүүжилт дөнгөж 40 хувьтай байлаа. Энэ жил ч гэсэн түүнээс дээрдсэн юм алга.

Санхүүжилттэй холбоотой асуудлыг тийм ч амар хялбар шийдчихдэг юм биш. Хэргийн учир нь Буриад улс өөрөө төсвийн бүрдүүлэлтийн хувьд ихээхэн хүндрэлтэй тулгарч байна. Гэвч бид улсын хил, хилийн зурваст Оросын үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд төлөвлөгөө, дэс дараалалтайгаар хүчээ улам нэмэгдүүлэх нь чухал гэдэг дээр Байгалын Чанд дахь хилийн тойргийнхонтой харилцан ойлголцож ажилладаг. Засгийн газар маань ч хилчдэд туслах талаар тодорхой арга хэмжээнүүдийг авсаар ирсэн юм.

1995 оны 9 дүгээр сард Буриадын Бүгд Найрамдах Улсын (ББНУ) Засгийн Газар "Оросын Холбооны Улсын Хилийн Тухай Хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол гаргаж, хил орчмын районд Ардын сайн дурын нөхөрлөлийн (АСДН) штабуудыг байгуулж ард иргэдийг сайн дурын үндсэн дээр улсын хил хамгаалалтад оролцуулах болсон.

АСДН-ийн үйл ажиллагааг зохицуулах үр ашгийг нь дээшлүүлэхийн тулд Бүгд Найрамдах Улсын АСДН-ийн штаб байгуулсан юм.

АСДН-ийн гишүүн болж, ОХУ-ын Хилийн цэргийн ангид ажиллах орон тооны бус ажилтны үйл ажиллагаагаа явуулах эрх үүрэг, нийгмийн баталгааг хуульчилсан эрх зүйн акт батлан гаргах талаар ОХУ-ын хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын байгууллагуудад зохих санал оруулаад байна.

Мөн түүнчлэн хил нэвтрэх пунктүүдийг байгуулах, тохижуулах,

хилийн зурваст сахиулах дэглэмийн арга хэмжээг хүчжүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч байна.

Байгалын Чанд дахь хилийн тойргийн Цэргийн Зөвлөлийн хурлаар "Улсын хил хамгаалалтын ашиг сонирхолд нийцүүлж цэрэг-шефийн холбоо байгуулж тэдгээрийг цаашид боловсронгуй болгох арга хэмжээний тухай" асуудлыг хэлэлцэхэд бид төлөөлөгчөө оролцуулж дараа нь засгийн газрынхаа хуралдаанаар энэ асуудлыг хэлэлцэж "Буриадын Бүгд Найрамдах Улсын район, үйлдвэр, байгууллагууд хилийн заставуудын цэрэг-шефийн холбоог хөгжүүлэх тухай" тогтоол гаргасан.

Ингэснээр манай Бүгд Найрамдах Улсын район үйлдвэрүүд хилийн заставуудыг хариуцдаг болж, буй болсон шефийн холбооны үр дүнд Хиагтын хилийн отрядад л гэхэд цэргийн албанд цэргийн шилэлт сонголт хийдэг болсон юм.

Бүгд Найрамдах Улсын Засгийн Газрын тэргүүний орлогч Л.П. Табалевийн оролцоотойгоор Хиагтын хилийн отрядын бааз дээр тулгуурлан орон нутгийн өөрөө удирдах байгууллага, томоохон үйлдвэр, албан газрын удирдлагын хүрээнд цэрэг-шефийн холбоог бэхжүүлэх асуудлаар зөвлөгөөн хийлээ.

Зөвлөлгөөнд оролцогчид өөрсдийн шеф заставуудаар явахдаа хилчин дөчдөн амьдрал ахуйг сайжруулах талаар тодорхой санал гаргаж байв.

Бид "Сибирийн хэлэлцээр" нийгэмлэгийн ерөнхий захиралд тус нийгэмлэгийн ойрын чуулганаар бус нутгийн Холбооны субъектүүдийг улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх Байгалын Чанд дахь Хилийн тойргийн хил хязгаарыг хамгаалахад бололцоотой техник төхөөрөмжөөр хангах бие бүрэлдэхүүний алба, ахуйн хэвийн нөхцөл бололцоог бүрдүүлэхэд туслахад оролцуулах асуудлыг хэлэлцэхийг санал болгосон юм. Өнөө үед Оросын Холбооны Хилийн алба бие даасан төрийн тусгай алба болж түүний үйл ажиллагааны үндсийг цэргийн байгууламж төдийгүй орон нутгийн хүчин (хасаг цэрэг, ардын сайн дурын нөхөрлөл, хэтдээ хилийн цагдаагийн байгууллага) зэрэг цэргийн бус байгууллага бүрдүүлэх болж байна.

Манай Бүгд Найрамдах Улсад эдгээр шинэлэг зүйлүүдэд хэрхэн хандаж байна вэ? Улс оронд өрнөж буй нийгэм эдийн засгийн бэрхшээлт үйл явц, зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж буй армийн эсрэг нэвтрүүлгүүд нь арми хилийн цэргийн албаны нэр хүндийг унагаж, цэрэг шефийн харилцааны тогтсон системийг задалж, залуучуудыг цэрэг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж буйд иргэд санаа зовниж байна. Гэвч шинэ нийгмийг байгуулж

цэрэг армийг бэхжүүлэх асуудлыг хил хязгаар эх орноо хамгаалах талаар үеэс үед уламжилж ирсэн ард түмний түүхэн уламжлалд тулгуурлахгүйгээр шийдвэрлэнэ гэж санахын ч хэрэггүй биз ээ. Ямар ч нийгмийн байгууламжийн үед арми ард түмний холбоог салгаж болохгүй. Арми хилийн цэргийнхээ хүчин чадлыг бэхжүүлэх асуудал төр засгийн гол үүргийн нэг байсан, байсаар ч байх нь дамжиггүй.

Хэдийгээр Буриадад нийгэм эдийн засгийн хүнд нөхцөлтэй байгаа ч хилчдэд туслах талаар бид чадах бүхнээ хийж хасаг цэрийг ч дэмжиж байна.

Хасаг омог бол орос улсын хилийг найдвартай хамгаалах түүхтэй буй болсон маш өвөрмөц тогтолцоо юм. Одоо манай Бүгд Найрамдах Улсад төрийн алба хаах түүний дотор улсын хил хамгаалах хүсэлт гаргасан Байгалын Чанд дахь хасаг цэргийн бүрэлдэхүүн, хасаг омгийнхныг улсын бүртгэлд бүртгэх бэлтгэл ажил хийгдэж байна.

Харамсалтай нь Холбооны төр засгийн байгууллагууд хасагуудыг улсын хил хамгаалах, хилийн зурваст хэв журам сахиулах ажилд идэвхитэй оролцуулах боломж олгох эрх зүйн баримт бичгүүдийг гаргаж өгөхгүй удааж байна.

Хил дээр хэв журам сахиулахад Засгийн газар, Орон нутгийн засаг захиргааны байгууллага, хилчид нь ямагт бие биендээ тус дэм болж байдаг. Энэ талаар ямар хэтийн төлөв байна вэ? Иймэрхүү харилцан туслалцсан жишээ олныг дурьдаж болох юм. Манай бүс нутгийн онцлогтой холбогдон гардаг байгалийн гамшгийн үр дагаварыг арилгахад хилчид бидэнд байнга тусалж байдаг. Харин бид тэдэнд чадах чинээгээрээ эд материал, хөрөнгийн тусламж үзүлдэг. 1994 онд Хиагтын хилийн отрядад 40 сая рубль, 1995 онд 36.5 сая рублийн тусламж үзүүлсэн. Энэ жил Бүгд Найрамдах Улсын Ойн Аж Ахуйн Яам хилийн пост барьж байгуулахад нь зориулж 1.5 мянган шоо метр мод бэлтгэж өглөө.

Орон нутгийн өөрөө удирдах байгууллага, үйлдвэр албан газрын дарга нар болон шефийн холбоо бүхий хилийн заставуудын удирдлагын хооронд хилчдийн эрүүл мэнд, хэвийн ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд материалын болон хөрөнгийн туслалцаа үзүүлэх талаар ярьж тохирсон зүйлүүд ч нэлээд бий.

Тэдний хэлхээ холбоо цаашид ч улам хөгжих болно гэдэгт би хувьдаа итгэлтэй байна.

Буриадын Бүгд Найрамдах Улсын боловсролын яамнаас дээд боловсрол, шинжлэх ухааны байгууллага эрхэлсэн газар, хилчид орон нутгийн ард иргэдээс тавьсан хүсэлтийг харгалзан "Хасаг цэргийн сэргэн мандалт" сургуулийн хөтөлбөрийг баталлаа.

Энэ жил Шар голын дунд сургууль шинэ шилжилтийн хөтөлбөрөөр хичээллэж эхлэх бөгөөд ингэснээр сурагчдын цэргийн албаны бэлтгэлийн түвшин ихээхэн сайжрах юм.

Ерөнхийлөгч миний бие цэргийн анги салбаруудаар явж хилийн албаны чанар байдалтай тогтмол танилцаж байдаг юм.

Хиагтын районд ажлаар явж байхдаа би Дээд Торей тосгоны уугуул Зөвлөлт Холбоот Улсын Баатар ахлах дэслэгч Гарамжавын Гармаевын нэрэмжит засталаар нэг бус удаа орж байсан юм.

Энэ застав бол Хиагтын районы хамгийн тэргүүний заставын нэг. Салбарын бие бүрэлдэхүүн нь улсын хилийн 20 км хэсгийг хамгаалдаг хил зөрчигч явж болзошгүй чиглэлд байрладаг учраас заставыг их анхаардаг.

Хилчид нь хоёр давхар байранд, офицер прапорщикууд нь орон сууцаар бүрэн хангагдсан юм байна.

Хилчидтэй ярилцаж байхад тэдний ихэнхи нь улсын хил хамгаалалтад маш хариуцлагатай хандаж үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа нь мэдрэгдэж байсан.

Харин энэ албыг хөнгөн гэж хэн ч хэлэхгүй бизээ.

Хилчдийн хилийн албаны чанарт сөргөөр нөлөөлж буй зүйл нь шатах тослох материал, хүнсний хангалтын доголдол юм. Мөн заставуудын хугацаат албаны цэргийн орон тоо ихээхэн дутуу байгаа явдал хүчирхэг учруулж байна.

Буриадын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн хувьд тойргийн нийт хилчдэд хүлээсэн үүргээ эх орончоор биелүүлж, албаны ур чадвараа улам дээшлүүлж, хилийн цэргийнхээ дайчин уламжлалыг цаашид нандигнан хадгалж хөгжүүлнэ гэдэгт итгэж найдаж явдгаа илэрхийлье. Эцэг хүний хувьд нийт хилчиддээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхан, энх амгалан бүхнийг ерөөе.

Өөрийн төрөл төрөгсөд ойр дотныхноо мартаггүй байж, албаа үнэнч шударгаар хаахыг хүсье.

**"Оросын Холбооны Улсын
Хилийн бодлогын асуудлууд"
эмхтгэлээс орчуулсан дэд хурандаа Ч.Дашдэлэг**